



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Үерийн усны аюулаас урьдчилан
сэргийлэх арга хэмжээ авах тухай

Улаанбаатар хотод төдийгүй нийт нутгаар олон жилийн дундажаас илүү бороо хур орж, гол, мөрөнгийн усны түвшин нэмэгдэж, тээврийн дэд бүтэц, тээвэрлэлтийн үйлчилгээнд хүндрэл, бэрхшээл учруулахуйц нөхцөл байдал үүсгэж байна.

Цаашид хур тунадас үргэлжлэн орох цаг агаарын урьдчилсан мэдээтэй байгаа тул үерийн усны аюулаас сэрэмжлүүлэх, үүсч болзошгүй аливаа осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгалийн гэнэтийн болзошгүй нөхцөл байдлын үед тээврийн аюулгүй байдлыг хангуулах, салбарын байгууллага, албан хаагчдын ажлын хариуцлага, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллахыг Салбарын нийт байгууллагын албан хаагч, аймаг, нийслэлийн Засаг дарга, авто замын өмчлөгч, эзэмшигч, хариуцагч аж ахуйн нэгж, байгууллага, төмөр замын суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, ашиглагч, төмөр замын тээвэрлэлт, усан замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагад Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

Нэг. Авто зам, замын байгууламж, тээвэрлэлтийн аюулгүй байдлын чиглэлээр захиалагч, зөвлөх байгууллагад:

1.1 Авто зам, замын байгууламжуудын ашиглалтын найдвартай байдал, ашиглалтын шаардлагууд болон тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс үерийн ус давж урсах магадлалтай, үерийн улмаас эвдрэл гардаг хэсгүүдэд усны тооцоо судалгааг үе шаттай хийлгэж, нэмэлт ус зайлуулах байгууламж, хамгаалалтын далан барих төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авах;

1.2 Захиалагч, зөвлөх байгууллагын зүгээс авто замын ашиглалтын хэвийн байдлыг хангуулах, засвар, арчлалтын ажлыг тогтоосон хугацаанд хийж, болзошгүй үерлэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа эсэхэд хяналт тавих.

Хариуцагч байгууллагад:

1.3 Авто замын арчлалт, урсгал засварыг хариуцагч аж ахуйн нэгж, байгууллагууд Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.5, 23.3.6 дахь заалтын дагуу гамшиг, ослын улмаас авто замд эвдрэл, гэмтэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатсан үед олон нийтэд мэдээлж, захиалагч болон зөвлөх байгууллагуудын хамт саадыг арилгах арга хэмжээг шуурхай авч ажиллах;

1.4 Байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас авто замд гарсан эвдрэл, гэмтлийг арилган тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж, холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;